Бүлэг	Дэд бүлэг	Товч агуулга
Бүлэг 1. Удиртгал	1.1. Хэрэгцээ, үндэслэл 1.2. Зорилго, зориулалт 1.3. Бүтэц, агуулга, хязгаарлалт 1.4. Арга аргачлал 1.5. Үр дүн, дүгнэлт 1.6. Зөвлөмж	Товч агуулга
Бүлэг 2. Дэлхий нийтийн болон Монгол Улсын ТХ ба ТХБ-ын хөгжлийн стратегийн удирдлага	2.1. "Тогтвортой хөгжил" ба "Тогтвортой хөгжлийн боловсрол"-ын хам утга 2.2. Дэлхий нийтийн түвшин дэх тогтвортой хөгжил ба тогтвортой хөгжлийн боловсролын стратегийн замнал, өрнөл, интеграц 2.3. Монгол Улс дахь тогтвортой хөгжил ба тогтвортой хөгжлийн стратегийн замнал, өрнөл, интеграц	<ul style="list-style-type: none"> • Тогтвортой хөгжлийн үзэл санааны үүсэл хөгжил, товч агуулга • Тогтвортой хөгжлийн тодорхойлолт, агуулга • Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааны үүсэл, хөгжил, товч агуулга • Тогтвортой хөгжлийн боловсролын тодорхойлолт, агуулга • Тогтвортой хөгжлийн стратегийн замнал, өрнөл • Тогтвортой хөгжлийн боловсролын стратегийн замнал, өрнөл • ТХ ба ТХБ-ын интеграц (1972-2015) үр дүн, цаашдын зорилт • Тогтвортой хөгжил, хөгжлийн боловсролын стратегийн замнал, өрнөл • ТХБ-ыг бага, дунд боловсролд интеграцлалсан бодлогын болон онол, арга зүйн шийдлүүд
Бүлэг 3. ЕБС-ийн сургалт, үйл ажиллагаанд ТХБ-ыг интеграцлах үндсэн чиглэл	3.1. Цогц чадамж, Тогтвортой байдлын цогц чадамж 3.2. ТХЗ-ын суралцахуйн зорилт 3.3. ТХЗ-ын сэдэв 3.4. ТХЗ-ын арга зүйн хандлага, арга, техник 3.5. ТХЗ-ын суралцахуйн зорилт, сэдэв, арга зүй, ТБ-ын цогц чадамж ба ЕБС-ийн цөм хөтөлбөр хоорондын хамаарал	<ul style="list-style-type: none"> • Цогц чадамжийн тухай ерөнхий ойлголт • Тогтвортой байдлын түлхүүр 8 цогц чадамж • ТБ-ын цогц чадамж ба башгийн ТХБ-ын цогц чадамж • ТХЗ-ын суралцахуйн зорилт, түүний кодын тайлал • ТХЗ-ын сэдэв, түүний кодын тайлал • ТХЗ-ын сургалтын арга, хандлага, түүний кодын тайлал
Бүлэг 4. ТХБ-ыг ЕБС-ийн сургалт, үйл ажиллагаанд интеграцлах чиглэл ба нэгж хичээлийн жишээнүүд	Долоон дэд бүлэг: 4.1. Бага боловсрол 4.2. Хэл, хүмүүнлэгийн ухаан 4.3. Математик, мэдээллийн технологи 4.4. Байгалийн ухаан 4.5. Түүх, нийгмийн ухаан 4.6. Урлаг, дизайн, технологи 4.7. Сургалтыг дэмжих үйл ажиллагаа	Судалдахуун тус бүр нь харгалзах боловсролын түвшингээр нэгдүгээрт, тухайн хичээлээр ТХБ-д оруулах хувь нэмэр, хоёрдугаарт, сонгосон нэгж хичээлээр ТХБ-д хувь нэмэр оруулах үндэслэл, нэгж хичээлийн жишээ төлөвлөлт гэсэн агуулгатай.

Гарын авлага нь төсөл хэрэгжүүлэх хугацаа, төслийн батлагдсан дизайны зэргээс хамаарч доор дурдсан хязгаарлалттай байлаа. Үүнд:

1. Монголын ЕБС-ийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд ТХБ-ын интеграцлагдсан байдлыг илрүүлэх судалгааны тусгайлан тусгайлан багас, хэрэгсэл, арга зүйг боловсруулахдаа голдуу 2015 оноос хойш ТХ, ТХБ-ын чиглэлээр гарсан ЮНЕСКО-ын баримт бичиг, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны материалуудад илүү төвлөрсөн болно.
2. Сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд ТХБ-ыг интеграцлагдсан байдлыг илрүүлэх судалгааны объектын ерөнхий боловсролын сургуульд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичиг гэсэн зөвхөн сургалтын үндсэн баримт бичгүүдээр хязгаарласан.
3. Гарын авлагад зөвлөмжилсэн нэгж хичээлүүдийн нэгдсэн туршилтыг тусгайлан явуулаагүй.
4. ТХБ-ыг цөм хөтөлбөр болон сургалтад интеграцлах боломжийг тодорхойлохдоо энэ удаад үнэлгээний асуудлыг тухайлан авч үзээгүй болно.

1.4. АРГА, АРГАЧЛАЛ

Энэхүү гарын авлагыг боловсруулах ажлын хүрээнд уг ажлыг гүйцэтгэсэн баг нь агуулгын хувьд далайцтай, арга зүйн хувьд шинэлэг, хэмжээний хувьд томоохон дараах 3 төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

- НҮБ болон Монгол Улсын Их Хурал, Засгийн газар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ТХ, ТХБ, ТХЗ-ын чиглэлээр батлагдан гарч, дэлхий нийтийн болон үндэсний хэмжээнд мөрдөгдөж буй, хөгжлийн бодлого, стратеги, онол, арга зүйн болон ЕБС-д мөрдөгдөж буй сургалтын үндсэн баримт бичгүүдийн нарийвчилсан судалгаа явуулах
- Судалгаанд хэрэглэх багаж хэрэгсэл, арга аргачлал, ТХЗ-ын суралцахуйн зорилтууд, сэдвүүд, арга техникүүдийг а) ЕБС-д судлах агуулгын чиглэл бүрт, б) бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин бүрийн судлагдахуун бүрт, в) үндэсний цөм хөтөлбөрт бүхэлдээ гэсэн 3 түвшинд хэрхэн туссан байдлыг үнэлж дүгнэсэн судалгааны үр дүнгүүд түүнчлэн нэгж хичээлд тэдгээрийг хэрхэн интеграцилж болохыг харуулсан жишээнүүдийг тус тус боловсруулах.
- Судалгаа явуулж, мэдээлэл боловсруулах, багаж хэрэгсэл, арга аргачлал бүтээх, нэгж хичээлийн агуулга, арга зүйг дэлгэх, судалгааны үр дүнг боловсруулах явцдаа бие дааж болон хамтран суралцах

Судалсан материал

Гарын авлагын 2-р бүлгийг боловсруулахад ТХ, ТХБ, ТХЗ-той холбоотойгоор бичигдсэн зарим түүхэн баримт бичгүүд болон 1972 оноос хойш НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудаас гаргасан хөгжлийн бодлого, стратегийн бараг бүх гол баримт бичгүүдийг харьцуулан судалж, ТХ, ТХБ-ын үзэл санааны үүсэл, хөгжлийн замнал ба өрнөлийг харилцан хамааралтайгаар бүхэлд нь тоймлон гаргасан. Улмаар Монголын УИХ ба Засгийн газраас батлан гаргасан хөгжлийн бодлого, стратеги, үндэсний хөтөлбөрүүд, холбогдох эрх зүйн актуудад тусгагдсан ТХ, ТХБ-ын асуудлыг судлахдаа энэ хоёр нэр томьёо хэрэглэсэн байдал, ТХБ-ын агуулга, арга зүй талаас нь илүү хандсан бөгөөд 2015 оноос хойш Монгол Улсад хийгдсэн судалгааны тайлангууд дахь үнэлгээ, дүгнэлт, санал зөвлөмжийг ашигласан.

Хэрвээ багш нар сонирхвол тус гарын авлагад өгөгдсөн гадаад, дотоодын холбогдох сайтудын URL хаягуудаар орж, нҮБ-ын болон Монгол Улсын хөгжлийн бодлого, стратегийн гол баримт бичгүүдийн агуулгад ТХ, НХ, ТХБ, ТХЗ, ТБ-ын цогц чадамжууд хэрхэн тусгагдсан байдлын нарийвчилсан судалгааг хийх боломжтой.

Гарын авлагын 2-р бүлгийн агуулгын тавилыг энэхүү гарын авлагыг хэрэглэх олон мянган багш нар маань өөрийнхөө, сурагчдынхаа, гэр бүл, хамт олон, орон нутаг, боловсролын салбар, Монгол Улсынхаа хөгжлийг Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагатай харьцуулж нэг хараад, бүтээлчээр эргэцүүлэхэд нь тустай байхаар тооцож дэглэсэн.

Гарын авлагын 3-р бүлгийг боловсруулахдаа ТХ, ТХБ, ТХЗ, ТБ-ын цогц чадамжийн чиглэлээр сүүлийн жилүүдэд ЮНЕСКО-оос гаргасан онол арга зүйн удирдамжийн 10 гаруй баримт бичиг, гарын авлага, бидний хийж буй ажилтай ижил төстэй гадаадын зарим улс орны 3 баримт бичгийг судалсан (Хавсралт 1.1). Тухайлбал, ЮНЕСКО-оос гаргасан дараах 3 баримт бичгийг нарийвчлан судалж, онол арга зүйдээ ашигталаа. Үүнд:

- "Тотвортой хөгжлийн зорилгын боловсрол: Суралцахуйн зорилтууд" буюу "Education for Sustainable Development Goals: Learning Objectives, (2017);
- "Цогц чадамжийг үнэлэх үзэл баримтлалын хүрээ" буюу "A Conceptual Framework for Competencies Assessment (2016);
- "Суралцахуйн хүлээгдэж буй үр дүнгийн түвшинчлэл ба хүлээн зөвшөөрөгдсөн байдал буюу "Level-setting and recognition of learning outcomes (2015)"

Мөн эдгээр баримт бичгийг боловсруулахад эшлэл болгосон олон улсад нэртэй эрдэмтдийн эрдэм шинжилгээний зарим өгүүлэл (Хавсралт 1.1)-ийг бүрэн эхээр нь уншиж судлан ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт ТХБ-ын интеграцилагдсан байдлыг шинжлэх багаж бүтээх, арга зүй боловсруулахад тус тус ашигласан.

Судалгааны шаардлагатай тохиолдолд суралцахуйн удирдаж, сурах бичгүүдийг хөтөлбөр, шаардлагатай тохиолдолд суралцахуйн удирдаж, сурах бичгүүдийг нэмж, нийт 230 гаруй сургалтын үндсэн баримт бичгийг ашигласан. Судалгааны объект болгосон сургалтын эдгээр баримт бичгүүдийг энэхүү гарын авлагад цаашид "цөм хөтөлбөр" (ЦХ) гэсэн ерөнхий нэг нэр томъёогоор хэрэглэнэ.

Бүтээсэн багаж, тэдгээрийг ажиллуулах аргачлал

Энэхүү гарын авлагын зориулалтын хүрээнд үндсэн хоёр багаж буюу Матриц 1 ба Матриц 2-ыг тус тус бүтээж ашигласан. ТХБ-ын үзэл санаа, агуулга, арга зүй нь манай цөм хөтөлбөрийн агуулга, арга зүйд хэрхэн интеграцилагдсан байдлыг үнэлэх шалгуураар ЮНЕСКО-ийн "ТХЗ: Суралцахуйн зорилт" (2017) зөвлөмжийн өгөгдсөн ТБ-ын 8 цогц чадамж, ТХ-ийн 17 зорилгын хүрээнд нийт 255 суралцахуйн зорилт, 171 сэдэв, 119 арга зүйн хандлага, арга, техникийг тус тус сонгож, нийт 553 индикатораар бүх ангийн бүх хичээлийн бүх цөм хөтөлбөрт үнэлгээ хийх хүчин чадалтай энэхүү хоёр матрицыг бүтээсэн болно.

Эхний багаж буюу Матриц 1 нь бага, суурь, бүрэн дүнд боловсролын сургалтын цөм хөтөлбөрүүд дэх суралцахуйн зорилтод ТХБ-ын агуулга буюу ТХЗ-ын хүрээнд санал болгосон сэдвүүдийн интеграцилагдсан байдлыг шинжлэх зориулалттай.

Харин хоёр дахь багаж буюу Матриц 2 нь цөм хөтөлбөрт агуулгаараа ТХБ-той интеграцилагдсан гэж тогтоогдож, сонгогдсон суралцахуйн зорилтыг ТХЗ-ын хүрээнд санал болгосон хандлага, арга техниктэй хэрхэн интеграцилж болохыг,

улмаар ТБ-ын аль цогц чадамжийн төлөвшилд хувь оруулах боломжтойг тогтоож, үндэслэлийг илрүүлэх зориулалттай.

Матриц 1 нь хоёр хэмжээст хөлгийн зарчмаар ажиллана. Хоёр хэмжээст хөлөг нь мөрийн дагууд ТХЗ бүрээр тодорхойлсон тус бүр 15 суралцахуйн зорилтыг баганын дагууд ТХЗ-ыг хангахад санал болгосон 10 сэдэв (зөвхөн ТХЗ13-т 11 сэдэвтэй)-ийг авсан. Эдгээр суралцахуйн зорилт ба сэдвийн огтлолцол нь 150 ннд (зөвхөн ТХЗ13-т 165 ннд)-тэй (Зураг 3.5.1) бөгөөд ТХЗ тус бүрээр буюу нийт хоёр хэмжээст 17 хөлөг байна.

Тухайн боловсролын түвшин, тухайн анги, тухайн судлагдахуун бүрээр цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт нэг бүрийг шинжлээд ТХ, ТХЗ-той хамааралтай байвал хоёр хэмжээст 17 хөлгийн нийт 2565 ннд (150 x 16 + 165)-ний харгалзах нүдэнд тэрхүү суралцахуйн зорилтыг кодын хамтаар бичнэ. Ингэж тодорхойлсон суралцахуйн зорилтыг ТХЗ-ын суралцахуйн зорилтын аль айд, хэддүгээр ангид хамаарахыг тоолох мөн дүнг товчоолж нэгтгэх (Зураг 3.5.1, 3.5.2)-ээр "автоматчилагдсан" ехсел-ийн файлыг Матриц 1 гэж нэрлэсэн. Төслийн багийн гишүүдийг Матриц 1 буюу энэ автоматчилагдсан файльтай хэрхэн ажиллах, цөм хөтөлбөр дэх тухайн суралцахуйн зорилт нь ТХБ-той интеграцилагдсан байдлыг хэрхэн тодорхойлох тусгай аргачлалаар хангаж, сургалт семинарын үед харилцан ярилцаж, тайлбарлаж, зөвлөж ажилласан.

ТБ-ын 8 цогц чадамж, ТХ-ийн 17 зорилгын хүрээнд нийт 255 суралцахуйн зорилт, 171 сэдэв, 119 арга, техникийг тус тус сонгож, нийт 553 индикатораар бүх ангийн бүх хичээлийн бүх цөм хөтөлбөрт үнэлгээ хийх, улмаар үр дүнг нэгтгэхэд томоохон хэмжээний өгөгдөл, тоо баримттай ажиллах болсон учраас бид мэдээллийг хураангуйлах, загварчлах, нууцлах, мэдээлэл хоорондын холбоог тогтоон эрэмбэлэх боломж олгодог, улмаар агуулгыг бүхэлд харж төсөөлөх, ухамсартайгаар хэрэглэх нөхцөл хангадаг; мэргэжлийн түвшинд хэрэглэхэд тохиромжтой мэдээлэл солилцооны дөвшилтэт хэл, хэрэгсэл болох КОД-ыг боловсруулж хэрэглэсэн.

Код	Түүний тайлал
ТХ301.ТМ2.	ТХ-ийн 1-р зорилгын Танин мэдэхүйн айн 2 дахь суралцахуйн зорилт
ТХ315.НСХ1.	ТХ-ийн 15-р зорилгын Нийгэмшил-сэтгэл хөдлөл айн 1 дэх суралцахуйн зорилт
ТХ310.ЗУ5.	ТХ-ийн 10-р зорилгын Зан үйлийн айн 5 дахь суралцахуйн зорилт
ТХ313.Сэ01.	ТХ-ийн 13-р зорилгын санал болгосон 1-р сэдэв
ТХ302.Аз4.	ТХ-ийн 2-р зорилгын жишээ болгосон 4 дэх арга

Хоёр дахь багаж буюу Матриц 2 нь нийт 10 баганатай нэг хэмжээст хөлгийн зарчмаар ажиллана. Төслийн багийн гишүүдийг Матриц 2-той хэрхэн ажиллах, тухайн суралцахуйн зорилтын ТХБ-той интеграцилагдсан байдлын үндэслэл болон суралцахуйн аргыг сонголт, үндэслэл, мөн ТБ-ын цогц чадамжид оруулах хувь нэмэр, түүний үндэслэлийг тус тус хэрхэн тодорхойлох тусгай аргачлалаар хангаж, сургалт семинарын үед тайлбарлаж, зөвлөж ажилласан. Ялангуяа ТБ-ын цогц чадамжид оруулах хувь нэмэр, түүний үндэслэлийг тодорхойлох нь "нэн шинэ" асуудал байсан болно.

Боловсруулсан бүтээгдэхүүн

Гарын авлагыг боловсруулах ажлын хүрээнд 5 төрлийн 149 бүтээгдэхүүн боловсруулсан (Хүснэгт 1.4.1).

Хүснэгт 1.4.1. Боловсруулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээ

Бүтээгдэхүүн	Товч агуулга	Үзүүлэлт
Боловсруулсан мэдээлэл	Дэлхий нийтийн болон Монгол Улс дахь ТХ, ТХБ-ын хөгжлийн замнал, өрнөл, интеграц, ТХЗ-ын төлөө боловсролын суралцахуйн зорилт, агуулга, арга хандлага, тогтвортой байдлын цогц чадамгауд	Гарын авлагын 2-р бүлэг Гарын авлагын 3-р бүлэг
Бүтээсэн багаж, аргачлал	Матриц 1. ЦХ-ийн суралцахуйн зорилт ба ТХЗ-ын суралцахуйн зорилт, сэдвийн хамаарал Матриц 2. ТХЗ-той интеграцилагдсан гэж тогтоосон ЦХ-ийн суралцахуйн зорилт түүнийг хэрэгжүүлэхэд хэрэглэхээр сонгосон ТХЗ-ын арга зүйн хандлага, арга техник, сурагчдын төлөвшилд хувь нэмэр оруулах ТБ-ын цогц чадамж ба тэдгээрийн хоорондох хамаарал	Гарын авлагын 4-р бүлгийн үр дүнг гаргахад хэрэглэсэн багажууд нь 4 төрлийн нийт 553 индикатортой.
Үр дүнгийн матрицууд	1-12 ангийн судлагдахуун бүрээр бөглөгдсөн 92 матриц	ТХЗ-ын суралцахуйн зорилт, ТХ, ТХЗ-ын сэдэв, ТБ-ын арга, техник, ТБ-ын цогц чадамж бүрийн тархалт, давтамж
Нөггөлдсөн үр дүнгүүд	Судлагдахууны агуулгын 7 чиглэлээр гаргасан үр дүнгүүд	Нэгж хичээл
Нэгж хичээлүүд	1-12 ангийн нийт 24 судлагдахуунаар боловсруулсан 46 хичээл	Нэгж хичээл
Жич: Матриц 1-ийн бөглөгдсөн матрицуудыг гарын авлагын номонд хавсаргаагүй бөгөөд үр дүнг Матриц 2-ыг боловсруулахад ашигласан болно.		

Багийн бүтэц, чиг үүрэг, менежмент

Тус гарын авлагыг боловсруулахад нийт 50 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг хамт олон оролцсон бөгөөд менежментийн баг, зөвлөх баг, судлагдахууны 7 дэд баг, эх бэлтгэл, хяналтын багийн зохион байгуулалтаар ажилласан. Зөвлөх багаас дэд багийн ахлагчдад, дэд багийн ахлагчаас гишүүдэд түгээн дэлгэрүүлэх "шаталсан" зарчмаар судалгааны багийн бүх гишүүд гарын авлага боловсруулах арга зүйг эзэмшиж хэрэглэн энэхүү гарын авлагыг боловсруулсан болно. Дараах хүснэгтээс Баг тус бүрийн хүлээх үүргээс энэхүү "шаталсан" зарчим хэрхэн ажил хэрэг болсныг тодорхой харж болно.

Багийн нэрс	Хүлээх үүрэг
1 Менежментийн баг	- Гарын авлага боловсруулах төслийг боловсруулж баг бүрдүүлэх - Гарын авлагыг боловсруулах үйл явцыг тасралтгүй удирдлага, зохион байгуулалтаар хангах - Зөвлөх болон дэд багуудын хамтын ажиллагааг уялдуулах, ажиллах болгож нөхцөлөөр хангах - Гарын авлагыг олон нийтэд танилцуулах цаашид түгээн дэлгэрүүлэх стратеги, чиглэлийг тодорхойлох.
2 Зөвлөх баг	- ТХ, ТХБ-ын хөгжлийн түухэн замнал, өрнөл, интеграцыг тоймлох, загварчлах - Нэгдсэн үр дүнг боловсруулах дүгнэлт зөвлөмж гаргах - Нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан, олон улсын чиг хандлагад нийцсэн бүтэц, агуулга, ялангуяа судлагдахуун тус бүрээр боловсруулах матриц 1, матриц 2-н загварчлал, арга зүйг боловсруулж, туршиж - Нийт 45 хүнтэй багийн гишүүдийг удавхижуулах үе шаттай сургалтуудыг зохион байгуулж, удирдан чиглүүлэх - Нэгж хичээлийн төлөвлөлтийн загвар, жишээг боловсруулж, дэд багийн ахлагчдаар хэлэлцүүлэх, тэдний боловсруулж, хянасан нэгж хичээлийн ахлагчдаар хэлэлцүүлэх, мэдлийг боловсруулж, арга зүйн зөвлөгөө өгөх - Гарын авлагын I, II, III бүлэг, товчилсон үгс, номзүйн хэсгийг боловсруулах

3 Дэд багууд	- Ахлагч - Дэд багийн ахлагчид тодорхой нэг судлагдахуун дээр матриц 1, матриц 2 ажиллуулж улмаар нэгж хичээлийн жишээг боловсруулах замаар судалгааны арга зүйг эзэмшиж - Дараа нь өөрийн эзэмшсэн туршлага, арга зүйд тулгуурлан дэд багийн гишүүдэд матриц 1, матриц 2, нэгж хичээлийн төлөвлөлтийн жишээг тус тус танилцуулж, тэдгээрийг хэрэглэх аргачлал заавар зөвлөмжийг нэгдсэн журмаар өгөх - Дэд багийн менежментийг хариуцсан гишүүдээ мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж нэгж хичээлүүдийг хянан, сайжруулах - Гишүүд - Дэд багийн гишүүд матриц 1, матриц 2, нэгж хичээлийн төлөвлөлтийн жишээг боловсруулах, туршиж, сайжруулах - Энэхүү үйл ажиллагаанд оролцох явцдаа үе шаттай сургалтуудад хамрагдан өөрийн мэдлэг чадварыг дээшлүүлэх - Гарын авлагыг боловсруулах явцад багаар ажиллах, нэг нэгэндээ зөвлөн туслалх
4 Эх бэлтгэл, хяналтын баг	- Багуудаас ирсэн материалуудыг цуглуулж, нэлтгэх, гарын авлагын эхийг бэлтгэх, хянуулах, засварлах - Гарын авлагын хэвлэлийн эхийн дизайныг боловсруулах - Гарын авлагын дүрмийн болон найруулгын алдааг хянаж, засварлах

1.5. ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Цөм хөтөлбөрт ТХБ-ын интеграцилагдсан байдлыг үнэлсэн үр дүнгүүд

Нийт 6 чиглэлийн 24 судлагдахуунаар боловсролын гурван түвшинд а) Агуулгын интеграцын 46 үр дүнгийн матрицаас ТХЗ-ын суралцахуйн зорилт, сэдвийн б) Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцын 46 үр дүнгийн матрицаас ТХБ-ын арга, техник, ТБ-ын цогц чадамжийн давтамж, тархалтыг тус тус нэгтгэн танилцуулж байна. Бид эдгээр тархалт, давтамж дахь зүй тогтол, хандлагыг энгийн дискриптив статистикийн түвшинд илэрхийлж, зарим боломжит тайлбарыг хийсэн болно. Үүнд:

- Боловсролын түвшингээс хамаарсан зүй тогтол, чиг хандлага
- ТХЗ-ын суралцахуйн зорилтын айнаас хамаарсан зүй тогтол, чиг хандлага
- Судлагдахууны чиглэл (онцлог)-ээс хамаарсан зүй тогтол, чиг хандлага
- а. **Агуулгын интеграцын тодорхойлогдсон байдал** (Үндэсний хэмжээнд)
ЕБС-ийн бага, суурь, бүрэн дүнд боловсролын цөм хөтөлбөр дэх заавал судлах агуулгын суралцахуйн зорилтод ТХБ-ын интеграцилагдсан байдлыг шинжлэх эхний багаж буюу матриц 1-ээс гарсан үр дүнг нэгтгэн энд танилцуулж байна.
ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрөөс давхардсан тоогоор нийт 567 суралцахуйн зорилт ТХЗ-д хамаарна гэж тодорхойлогдсон байна (Хавсралт 1.2.). Тэдгээр нь ТХЗ-ын суралцахуйн зорилтуудад дараах тархалттайгаар харгалзаж байна. Хамгийн олон буюу цөм хөтөлбөрийн 108 (18.8%) суралцахуйн зорилт "ТХ303. Сайн эрүүл мэнд ба сайн сайхан байдал"-д, хамгийн цөөн буюу 4 (0.7%) суралцахуйн зорилт "ТХ314. Усан доорх амьдрал"-д тус тус хамаарч байна (Зураг 1.5.1, Хүснэгт 1.5.1.).

ажиллагаа голлох үүрэгтэй) гэсэн 3 судлагдахууны чиглэл илүү чухал хувь нэмэр оруулахаар байна. Харин "ТХ307. Боломжийн үнэтэй, цэвэр эрчим хүч"-д Байгалийн ухаан (Хими болон Физик)-ы судлагдахууны чиглэл голлох үүрэг гүйцэтгэхээр байхад "ТХ311. Тогтвортой хот суурин, оршин суугчид Нийгмийн ухаан (ялангуяа ББ-ын Хүн ба орчин)-ы судлагдахууны чиглэл голлох үүрэг гүйцэтгэхээр байна.

Хүснэгт 1.5.3. Цөм хөтөлбөрийн ТХ3-д хамаарах суралцахуйн зорилт
(Судлагдахууны чиглэл, ТХ3-оор)

ТХЗ	Судлагдахууны чиглэл										Нийт
	Хэл, хүмүүнлэгийн ухаан	Математик, мэдээллийн технологи	Түүх, нийгмийн ухаан	Урлаг, дизайн, технологи	Байгалийн ухаан	Сургалтыг дэмжих үйл ажиллагаа					
ТХ301	3	4	2	2	2	2	2	18	10	5	16
ТХ302	1	2	2	4	9	6	24	6	33	24	
ТХ303	45	2	8	7	30	16	108				
ТХ304	15	4	4	7	1	21	52				
ТХ305	1	6	1	1	6	6	14				
ТХ306	7	7	1	2	18	10	45				
ТХ307	2	1	1	24	24	6	33				
ТХ308	5	7	5	7	4	28					
ТХ309	1	2	2	1	8	3	17				
ТХ310	1	4	4	2	2	5	12				
ТХ311	5	2	24	4	4	7	46				
ТХ312	7	8	6	6	11	4	36				
ТХ313	5	7	2	2	19	5	38				
ТХ314				1	1	2	4				
ТХ315	11	2	5	6	30	10	64				
ТХ316	1	1	6	1	1	7	16				
ТХ317		3	4	1	1	5	14				
Тоо	102	37	91	48	167	122	567				
%	18.0%	6.5%	16.0%	8.5%	29.5%	21.5%	100%				

ТХЗ-ын суралцахуйн зорилтын 3 айд хамаарах цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын тархалт харилцан адилгүй байна. Тухайлбал, Танин мэдэхүйн айд хамаарах цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт олон байхад Байгалийн ухааны судлагдахуун ихээхэн нөлөөлсөн байна (Хүснэгт 1.5.4). Тухайлбал, Бу-ы цөм хөтөлбөрийн 121 суралцахуйн зорилт Танин мэдэхүйн айд хамаарч байгаа нь нийт суралцахуйн зорилтын 21.3%, Бу-ны нийт 167 суралцахуйн зорилтын 72.5%-ийг эзэлж байна.

Хүснэгт 1.5.4. Цөм хөтөлбөрийн ТХ3-д хамаарах суралцахуйн зорилт
(Судлагдахууны чиглэл, ТХЗ-ын СЗ-ын айсаар)

Судлагдахууны чиглэл	ТХЗ-ын суралцахуйн зорилт			Нийт
	Танин мэдэхүйн	Нийгэмшил-сэтгэл хөдөлгөөн	Зан үйлдлийн	
Хэл, хүмүүнлэгийн ухаан	42	33	27	102
	7.4%	5.8%	4.8%	18.0%

Математик, мэдээллийн технологи	21	9	7	37
	3.7%	1.6%	1.2%	6.5%
Түүх, нийгмийн ухаан	40	34	17	91
	7.1%	6.0%	3.0%	16.0%
Урлаг, дизайн, технологи	15	22	11	48
	2.6%	3.9%	1.9%	8.5%
Байгалийн ухаан	121	24	22	167
	21.3%	4.2%	3.9%	29.5%
Сургалтыг дэмжих үйл ажиллагаа	26	58	38	122
	4.6%	10.2%	6.7%	21.5%
Нийт	265	180	122	567
	46.7%	31.8%	21.5%	100%

СДУА-ны чиглэлээр тодорхойлогдсон цөм хөтөлбөрийн 58 суралцахуйн зорилт нь Нийгэмшил-сэтгэл хөдөлгөөн айд хамаарч байгаа нь нийт суралцахуйн зорилтын 10.2%, СДУА-ны нийт 122 суралцахуйн зорилтын 47.5%-ийг эзэлж байна.

Гарын авлагын 4-р бүлгээс судлагдахууны агуулгын чиглэл тус бүрийн, судлагдахуун (хичээл) тус бүрийн хувьд ТХБ-ын агуулгын интерац хэрхэн тодорхойлогдсонг дэлгэрүүлэн үзнэ үү. Цөм хөтөлбөрийн зорилт, зорилт, арга зүйн зарчимд ТХБ-ыг үндсэн агуулга, нэр томъёогоор нь тусгасан эсэхээс хамаарч тухайн хичээлийн хувьд боловсролын түвшнээс хамаарсан ялгаа ажиглагдаж байхад судлагдахууны агуулгын чиглэл хооронд цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын тавил, онцлогоос хамаарсан ялгаа (жишээ нь, БУ ба ХХУ) бас ажиглагдаж байгаа болно.

б. Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцын тодорхойлогдсон байдал (Үндэсний хэмжээнд)

Өмнөх хэсэгт цөм хөтөлбөрийн тухайн нэг суралцахуйн зорилт нь ТХЗ-ын ямар сэдэв, ТХЗ-ын аль суралцахуйн зорилтод хамаарахыг өөрөөр хэлбэл, цөм хөтөлбөр дэх ТХБ-ын агуулгын интеграцыг матриц 1-ээр илрүүлж тодорхойлсон бол энэ хэсэгт ТХЗ-ын тухайн сэдвийн хүрээнд тодорхойлогдсон суралцахуйн зорилтууд (Цөм хөтөлбөрийн болон ТХЗ-ын төлөөх боловсролын)-ыг хэрэгжүүлэхэд тохирох, ТХЗ-ын арга зүйд хамаарах арга, техникийн сонголт, улмаар төвлөсөн зорилт, нарийвчилсан агуулга (сэдэв) бүхий суралтаар суралцаж ТБ-ын ямар цогц чадамж төлөвшихөд нь аль хэр хувь нэмэр оруулах боломжтойг тодорхойлсон Матриц 2-ын үр дүнг нэгтгэн танилцуулж байна.

Агуулгын интеграцын судалгаагаар тодорхойлогдсон 567 суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд ТХЗ-ын арга зүйн хандлагын 4 төрлийн арга, техникээс давхардсан тоогоор 895 аргыг хэрэглэж болохоор тодорхойлсон байна (Хавсралт 1.3, Хүснэгт 1.5.5). "Шинжилгээ, судалгаа хийх" төрлийн арга харьцангуйгаар хамгийн олон сонгогдож байгаа нь СБ-ын цөм хөтөлбөрийн "шинжилгээ ухаанч арга барил төлөвшүүлэх", Бүрэн дүнд боловсролын "... шинжилгээ ухааны үндэс, судалгааны аргыг эзэмшүүлэх..." зэрэг зорилттой тус тус нийцэж байна.

Хүснэгт 1.5.5. Байгалийн ухааны цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт ба ТХЗ-ыг хангах сургалтын арга (боловсролын түвшинээр)

БТ	ТХЗ-ын төлөөх боловсролын сургалтын арга				Нийт
	Бодит үйл ажиллагаанд оролцох	Шинжилгээ/ судалгаа хийх	Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх	Алсын хараатай болох	
ББ	72	59	53	37	221 (24.7%)
СБ	97	102	109	61	369 (41.2%)
БДБ	66	136	71	32	305 (34.1%)
Нийт	235 (26.3%)	297 (33.2%)	233 (26.0%)	130 (14.5%)	895 (100%)

Судлагдахууны агуулгын чиглэлээр авч үзвэл, Математик, мэдээллийн технологи, Түүх, нийгмийн ухаан, Байгалийн ухаанд “Шинжилгээ/судалгаа хийх” төрлийн арга түлхүү хэрэглэгдэхээр байхад Хэл, хүмүүнлэгийн ухаанд “Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх” арга, Сургалтыг дэмжих үйл ажиллагаанд “Бодит үйл ажиллагаанд оролцох” арга тус тус түлхүү хэрэглэгдэж байгаа нь судлагдахууны агуулгын чиглэл бүрийн онцлогийг тодорхой хэмжээнд илэрхийлж байна (Хүснэгт 1.5.6).

Хүснэгт 1.5.6. Байгалийн ухааны цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт ба ТХЗ-ыг хангах сургалтын арга (судлагдахууны чиглэлээр)

Судлагдахууны чиглэл	БТ	ТХЗ-ын төлөөх боловсролын сургалтын арга						Нийт
		Бодит үйл ажиллагаанд оролцох	Шинжилгээ/ судалгаа хийх	Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх	Алсын хараатай болох	Шүүмжлэлтэй харьтат болох	Нийт	
Хэл, хүмүүнлэгийн ухаан	ББ	16	11	11	6	6	44	
	СБ	20	9	27	8	8	64	
	БДБ	15	27	32	3	3	77	
Математик, мэдээллийн технологи	ББ	3	2	2	3	3	10	
	СБ	8	11	4	6	6	29	
	БДБ	6	11	7	6	6	30	
Түүх, нийгмийн ухаан	ББ	21	34	17	15	15	87	
	СБ	4	17	18	6	6	45	
	БДБ	6	11	6	3	3	26	
Урлаг, дизайн, технологи	ББ	31 (3.5%)	62 (6.9%)	41 (4.6%)	24 (2.7%)	24 (2.7%)	158 (17.7%)	
	СБ	3	2	7	1	1	13	
	БДБ	8	8	8	2	2	26	
Байгалийн ухаан	ББ	2	3	0	0	0	5	
	СБ	13 (1.5%)	13 (1.5%)	15 (1.7%)	3 (0.3%)	3 (0.3%)	44 (4.9%)	
	БДБ	4	2	2	3	3	11	
Сургалтыг дэмжих үйл ажиллагаа	ББ	21	32	27	18	18	98	
	СБ	26	69	19	7	7	121	
	БДБ	51 (5.7%)	103 (11.5%)	48 (5.4%)	28 (3.1%)	230 (25.7%)		
Нийт	ББ	25	8	14	9	9	56	
	СБ	36	25	25	21	13	107	
	БДБ	11	15	7	13	13	46	
Нийт	72 (8.0%)	48 (5.4%)	46 (5.1%)	43 (4.8%)	209 (23.4%)			

Агуулгын интеграцын судалгаагаар тодорхойлогдсон 567 суралцахуйн зорилтыг хэрэгжүүлснээр ТБ-ын 8 цогц чадамжийн төлөвшилд хувь нэмэр оруулах боломж давхардсан тоогоор 957 тодорхойлогдсон байна (Хавсралт 1.4, Хүснэгт 1.5.7). “1. **Тогтолцоот сэтгэлгээний**”, “2. **Урьдчилан тооцоолох**”, “5. **Хамтран ажиллах**” цогц чадамжийн төлөвшилд харьцангуй илүү хувь нэмэр оруулах боломжтой гэж үзсэн бол “3. **Хэм хэмжээний**”, “4. **Стратегийн**”, “8. **Асуудал шийдвэрлэх нэгдсэн**” цогц чадамжийн төлөвшилд хувь нэмэр оруулах боломж нэлээд бага хувийг эзэлж байгаа нь ТХЗ-ын Танин мэдэхүйн айд хамаарах суралцахуйн зорилтын эзлэх хувь их байсантай холбоотой байж болох юм.

Хүснэгт 1.5.7. ТБ-ын цогц чадамжийн төлөвшилд цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын оруулах хувь нэмэр (боловсролын түвшинээр)

№	Боловсролын түвшин	ТБ-ын цогц чадамж							Нийт	
		1. Тогтолцоот сэтгэлгээний	2. Урьдчилан тооцоолох	3. Хэм хэмжээний	4. Стратегийн	5. Хамтран ажиллах	6. Шүүмжлэлт сэтгэлгээний	7. Өөрийгөө таньж мэдэх		8. Асуудал шийдвэрлэх нэгдсэн
	Бага	30	36	14	20	49	32	31	21	233
	Суурь	73	66	26	25	83	66	67	13	419
	Бүрэн дунд	78	57	26	11	46	38	38	11	305
	Нийт	181	159	66	56	178	136	136	45	957
	Хувь	18.9%	16.6%	6.9%	5.9%	18.6%	14.2%	14.2%	4.7%	100.0%

ТБ-ын цогц чадамжид оруулах хувь нэмрийг судлагдахууны агуулгын чиглэл (Хүснэгт 1.5.8)-ээр авч үзвэл Байгалийн ухааны хичээлүүд “1. **Тогтолцоот сэтгэлгээний**”, “2. **Урьдчилан тооцоолох**” цогц чадамж, Хэл, хүмүүнлэгийн ухаан, Түүх, нийгмийн ухаан, Сургалтыг дэмжих үйл ажиллагааны чиглэлийн хичээлийн хөтөлбөр “5. **Хамтран ажиллах**”, “7. **Өөрийгөө таньж мэдэх**” цогц чадамжийн төлөвшилд оруулах хувь нэмэр харьцангуй их тодорхойлогдсон байгаа нь судлагдахууны агуулгын чиглэлийн онцлогтой нийцэж байна.

Хүснэгт 1.5.8. ТБ-ын цогц чадамжийн төлөвшилд цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын оруулах хувь нэмэр (судлагдахууны чиглэлээр)

Судлагдахууны чиглэл	БТ	ТБ-ын цогц чадамж										Нийт
		1. Тогтолцоот сэтгэлгээний	2. Үрдчилнэн тооцоолох	3. Хэм хэмжээний	4. Стратегийн	5. Хамтран ажлгах	6. Шүүмжлэлт сэтгэлгээний	7. Өөрийгөө Тэнж мэдэх	8. Асуудал шийдвэрлэх нэгдсэн			
Хэл, хүмүүнлэгийн ухаан	ББ	7	11	5	3	14	7	7	0	54		
	СБ	10	10	6	3	29	19	22	4	103		
	БДБ	16	11	11	0	17	17	16	1	89		
	Нийт	33	32	22	6	60	43	45	5	246		
	Хувь	3.4%	3.3%	2.3%	0.6%	6.3%	4.5%	4.7%	0.5%	25.7%		
Математик, мэдээллийн технологи	ББ	0	3	1	1	0	0	1	1	7		
	СБ	7	8	4	2	4	3	0	1	29		
	БДБ	3	5	1	2	4	3	1	1	20		
	Нийт	10	16	6	5	8	6	2	3	56		
	Хувь	1.0%	1.7%	0.6%	0.5%	0.8%	0.6%	0.2%	0.3%	5.9%		
Түүх, нийгмийн ухаан	ББ	12	12	5	6	19	12	11	16	93		
	СБ	5	8	1	0	2	13	4	0	33		
	БДБ	8	1	4	3	3	3	2	1	25		
	Нийт	25	21	10	9	24	28	17	17	151		
	Хувь	2.6%	2.2%	1.0%	0.9%	2.5%	2.9%	1.8%	1.8%	15.8%		
Урлаг, дизайн, технологи	ББ	4	1	0	0	3	6	4	0	18		
	СБ	10	3	3	2	4	4	5	1	32		
	БДБ	1	2	2	1	4	0	1	0	11		
	Нийт	15	6	5	3	11	10	10	1	61		
	Хувь	1.6%	0.6%	0.5%	0.3%	1.1%	1.0%	1.0%	0.1%	6.4%		
Байгалийн ухаан	ББ	2	2	0	2	1	0	1	0	8		
	СБ	23	22	7	9	16	14	17	4	112		
	БДБ	50	32	6	4	12	11	9	8	132		
	Нийт	75	56	13	15	29	25	27	12	252		
	Хувь	7.8%	5.9%	1.4%	1.6%	3.0%	2.6%	2.8%	1.3%	26.3%		
Сургалтыг дэмжих үйл ажиллагаа	ББ	5	7	3	8	12	7	7	4	53		
	СБ	18	15	5	9	28	13	19	3	110		
	БДБ	0	6	2	1	6	4	9	0	28		
	Нийт	23	28	10	18	46	24	35	7	191		
	Хувь	2.4%	2.9%	1.0%	1.9%	4.8%	2.5%	3.7%	0.7%	20.0%		

Гарын авлагын 4-р бүлгээс судлагдахууны агуулгын чиглэл тус бүрийн, судлагдахуун (хичээл) тус бүрийн хувьд цөм хөтөлбөр дэх ТХЗ, ТХБ-ын арга зүй, ТБ-ын цогц чадамжийн интеграцын тодорхойлогдсон байдлын тайлбарыг дэлгэрүүлэн үзнэ үү. Агуулгын интеграц тодорхойлоход ажиглагдсан онцлог, ялгаа нь арга зүй, цогц чадамжийн хувьд ч мөн залгамж холбоотойгоор тайлбарлагдаж байгаа болно.

Дүгнэлт

1. Энэхүү гарын авлагыг боловсруулах ажлын хүрээнд маш богино хугацаанд холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллийн оролцоотойгоор судалгаанд

зориулж, тусгайлан бүтээсэн өгөгдлийн бүртгэл ба үр дүнгийн боловсруулалт нь автоматчиглагдсан багаж хэрэгслийн тусламжтайгаар сургалтын үндсэн баримт бичгүүдэд тулгуурлан сургалтын төлөвлөгөөнд заагдсан бүх ангийн бүх судлагдахуун-хичээлүүд, сургалтыг дэмжих бүх хэлбэрийн үйл ажиллагааг тус тус хамарсан, судалгааны үр дүнг бага, суурь, бүрэн дунд боловсролын бүх түвшингээр нэгтгэсэн, томоохон хэмжээний суурь судалгаа хийгдсэн болно.

2. НҮБ-аас 1972-2017 оны хооронд батлан гаргасан гол баримт бичгүүд болон бусад эх сурвалжуудын судалгаанд үндэслэн дэлхий нийтийн хэмжээнд ТХ, ТХБ-ын үзэл баримтлал, үйл хэргийн хөгжлийн замнал, өрнөлийн тоймыг түүхчлэн өгүүлж, холбогдох дүгнэлтүүдийг хийж, ТХ-ийн тодорхой үе шатуудад харгалзан 4 удаагийн цикл бүхий ТХБ-ын хөгжлийн үйл явцын бүдүүвчийг боловсруулсан.
3. УИХ ба ЗГ-ын шийдвэрээр батлагдсан Монгол Улсын хөгжлийн стратегийн баримт бичгүүдийн судалгаанд үндэслэн Монгол Улс дахь ТХ ба ТХБ-ын хөгжлийн бодлого, стратегийн замнал өрнөлийг тоймлож, холбогдох зарим дүгнэлтүүд гаргасан бөгөөд тухайлбал, ТХ ба ТХБ-ын хөгжлийн бодлого, стратегийн замналыг 3 үе шатад ялгаж, тодорхойлсон. Түүнчлэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлагдсан бага, дунд боловсролын стандарт ба кирриколимиийг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал, боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрүүдийн хүрээнд ТХБ-ыг бага, дунд боловсролд интеграцилсан бодлогын болон онол, арга зүйн шийдлүүдийг товч танилцуулж, холбогдох дүгнэлтүүдийг хийсэн.
4. Энэхүү гарын авлагын 2-р бүлэг нь дэлхий нийтийн болон Монгол Улсын ТХ ба ТХБ-ын хөгжлийн замнал, өрнөлийг тоймлон уялдаа холбоонд нь илүү цэгцлэгээр нэгтгэн дүгнэсэн, сонирхсон хүмүүст гүнзгийрүүлэн судлах эх үүсвэрүүдийг зааж өгсөн боловсролын салбар дахь харьцангуй түгээмэл хэрэглээтэй бүтээл болсон гэж үзэж байна. Энэ бүлэгт өгөгдсөн мэдээлэл нь хэрэглэгчдэд ТХ, ТХБ-ын хөгжлийн дэлхий нийтийн түвшинд бараг хагас зууны хийгээд үндэсний түвшинд 30-аад жилийн замнал, өрнөлийн бүдүүвчлэн тоймлож, нэг хавтгай дээр тавьж харах боломж олгосон, хөгжлийн дүнд ба урт хугацааны стратегийн төлөвлөлт хийхэд тус болох ач холбогдолтой юм. Учир нь стратегийн төлөвлөлтөд "backcasting" хийхгүйгээр "forecasting" хийх буюу алсын хараагаа тодорхойлох боломжгүй гэж үздэг.
5. Гарын авлага боловсруулсан багийн судлаач-зөвлөхүүдийн багаас сургалт болон сургалтыг дэмжих үйл ажиллагаанд ТХБ-ыг интеграцилж амилуулахад ашиглаж болох нэгэн шинэлэг арга зүй (Матриц 1 ба 2, тэдгээрийг ашиглах аргачлал)-г боловсруулсан. Энэ арга зүйг цаашид хөгжүүлэн хэрэглэж, боловсрол ба суралцахуйд ТХБ-ыг интеграцилж чадсан нөхцөлд байданд эргээд ТХ-д боловсролыг интеграцилах нэгэн бодит боломж бүрдэнэ.
6. Энэхүү гарын авлага нь судалгаанд суурилсан үр дүнгүүдэд тулгуурлан боловсрогдсон учир агуулга, арга зүйн хувьд ч хэмжээ, хэрэглээ, ач холбогдлын хувьд ч ижил төрлийн өмнөх гарын авлагуудаас ихээхэн ялгаатай.
7. Монгол Улсын ЕБС-ийн цөм хөтөлбөрт ТХБ-ын интеграцилагдсан байдлыг ТХЗ-ын төлөөх боловсролын суралцахуйн зорилт, түүнд хамаарах сэдэв ба арга хандлагыг шалгуур болгон төслийн багийн судлаач-зөвлөхүүдийн бүтээсэн тусгай багажуудаар үнэлж үзээд дараах дэд дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

- 7.1. Агуулгын интеграцыг илрүүлэх судалгаагаар ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрөөс давхардсан тоогоор нийт 567 суралцахуйн зорилт ТХ3-д хамаарахаар тодорхойлогджээ.
- 7.2. Агуулгын интеграцын судалгаагаар тодорхойлогдсон 567 суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд ТХ3-ын арга зүйн хандлагын 4 төрлийн аргад харгалзах давхардсан тоогоор 895 арга, техникийг хэрэглэж болохоор тодорхойлсон байна.
- 7.3. Цөм хөтөлбөрөөс тодорхойлогдсон 567 суралцахуйн зорилтыг 895 арга, техник хэрэглэн хэрэгжүүлснээр ТБ-ын 8 цогц чадамжийн төлөвшилд хувь нэмэр оруулах 957 боломж байгааг тодорхойлжээ.
- 7.4. ТХ3-ын төлөөх боловсролын суралцахуйн зорилт, түүнд хамаарах сэдэв, арга хандлага нь цөм хөтөлбөрийн боловсролын түвшингүүд, судлагдахуун агуулгын чиглэл, судлагдахуун бүрээр ялгаатай, өөрийн өөрийн онцлогтойгоор тусгагдсан байна.
8. Монгол Улсын ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт ТХБ зорилго, агуулгын хувьд харьцангуй сайн интеграцчилгдсан байна. Гэхдээ боловсролын түвшин бүрийн сургалтын цөм хөтөлбөрийн бүтэц, дизайны ялгаатай байдал, судлагдахууны агуулгын чиглэлүүдийн онцлогууд, хөтөлбөрүүдийн боловруулалтын түвшин жигд бус байдал зэргээс хамаарч цөм хөтөлбөрт ТХБ-ийн интеграцчилгдсан байдлыг илрүүлэх ажиллагаа нь судалгаанд сонгогдсон эх материал бүрийн хувьд ялгаатай аргачлалаар явагдахад хүргэсэн болно.
9. ТХБ-ыг ЕБС-ийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилж чиглээр баримтлах бодлого стратегийн төлөвлөлт, хэрэгжилтийн менежмент, хяналт-шинжилгээ үнэлгээнийхээ тогтолцоог ТХ3-2030 ба "ТХ3 4-Боловсрол 2030 үйлэйн хүрээ"-нд тодорхойлсон ТХБ-ын шинэ алсын хараанд нийцүүлэн тохируулж, Монгол Улсын боловсролын тогтолцооны ажиллагааг бүхэлд нь хувирган өөрчлөхөд нэн тэргүүнд бие даасан тусгай судалгаа, сургалтууд шаардагдаж байна.
10. ЮНЕСКО-оос зөвлөмжилсөн ТХ3-ын төлөө боловсролын суралцахуйн зорилго, ТХ-ийн хүрээнд санал болгож буй сэдвүүд, ТХ3-ын арга зүйн хандлагууд, ТБ-ын цогц чадамжийн хүрээнд тусгайлан боловсруулан арга зүй, багаж хэрэгслийн тусламжтайгаар Монголын ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт тэдгээрийн интеграцчилгдсан байдлыг илрүүлэх замаар сургуулийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд ТХ3-ын суралцахуйн зорилтуудын хэрэгжилт, ТБ-ын цогц чадамжид тус тус хувь нэмэр оруулж чадахуйцаар нэгж хичээлийг агуулга, арга зүй, үнэлгээг дэлгэх боломжтой нь харагдаж байна.
11. Гарын авлага боловсруулах явцад ЮНЕСКО-оос зөвлөмжилсөн нийтлэг удирдамжийг бүх нийтийн буюу суралцагч бүрийн гэсэн утгаар тодорхойлсон тул улс орнууд энэ удирдамжийн дагуу сургалтын үндэсний хөтөлбөр, сурах бичиг зэрэг ТХБ-ын интеграцилагдсан байдлыг үнэлэх, шинэчлэн сайжруулахад ашиглахдаа боловсролын түвшин бүрийн ялгаа, судлагдахууны агуулгын чиглэлийн онцлог тус тус нийцүүлэн өөрийн хэрэгцээндээ үндэслэсэн тусгайлсан багаж хэрэгсэл, арга зүйг боловсруулах, сонгох шаардлагатай нь харадсан. ТХ3-ын суралцахуйн зорилтуудыг боловсролын түвшингээс хамааруулж түвшинчлэн оноож нарийвчлах шаардлагатай.

12. Гарын авлага боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн судалгааны үр дүнд боловсролыг бүхэлд нь ТХ-ийн төлөө хувирган өөрчлөх гүн гүнзгий онол, арга зүйн үндэслэл бүхий суурь шийдлүүдийн цогц болох ТХ3 бүрийг хангахад шаардагдах суралцахуйн зорилтууд, санал болгож буй салбар дамнасан ойлголт ухагдахуун, зарчим бүхий ТХ-ийн сэдвүүд, суралцахуйн конструктив онолд тулгуурласан арга зүйн хандлага, арга техникүүд, ТБ-ын цогц чадамжуудын агуулга, мөн чанарыг тус бүрд нь болон харилцан хамааралд нь ухааж ойлгохүйгээр үр өгөөжтэй үйл эрхлэх боломжийг нь харагдсан. Энэ утгаараа **зорилгын төлөөх боловсрол** (ТХЗБ) хэмээх *доо шилнэ судлагдахуун* үүсэн бүрэлдэж байна хэмээн гарын авлага боловсруулсан баг үзэж байна.
13. Иймд бүх түвшний бодлого, боловсруулагчид, шийдвэр гаргагчид, сургалтын хөтөлбөр боловсруулагчид, үнэлгээний экспертүүд, арга зүйчид, сургуулийн удирдлагууд, ялангуяа судлаачид, багш нар энэ шинэ судлагдахууныг судалж, юуны өмнө ТХ/ТХБ/ТХЗ/ТБ-ын цогц чадамжийн хэл ухагдахуунд тайлагдах хойшлуулагшгүй шаардлага үүсээд байна.

1.6. Зөвлөмж

1. ТХЗБ нь боловсролыг хувирган өөрчлөх суурь шийдлүүдийн цогц болохыг танин мэдэхүйн хувьд хүлээн зөвшөөрч эдгээр шийдлийг бодит үйл болгоход Монгол Улсын төрөөс ТХ, ТХБ-ын талаар баримтлах бодлого, стратегия хянан үзэж, дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрсөн дээрх цогц шийдлүүдийг хэрэгжүүлж чадахуйцаар тэдгээрийг илүү тод томруун утга агуулгаар баяжуулан дотоод холбоонд нь нягт намбай интеграцилан ойлгож, хэрэглэхэд хялбар, цэгцтэй, барьцтай байхаар хэлбэржүүлэн тогтвортой баримтлан мөрдөхөд салбарын яам, агентлагууд санаачилгатай, хариуцлагатай ажиллах нь чухал байна.
2. Сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичгүүдээ хэрэгжүүлэх, сайжруулахдаа юуны өмнө зориулалтын багаж хэрэгсэл бүхий тусгай арга зүйнүүд боловсруулах цогц судалгааг чанарын баталгаа хангахуйц бодит хугацаатай байхаар төлөвлөн явуулах шаардлагатай.
3. Тусгайлсан төлөвлөгөө, менежментийн дагуу хүний нөөцөө чадавхижуулах зайлшгүй хэрэгцээ байна. Хүний нөөцийг чадавхижуулах үйл ажиллагааг зөвхөн олон хэлбэрээр давтан сургах бус, ТХБ-ын арга хандлагыг хэрэглэж, хүн бүрийг **"суралцагч"** хэмээн үзэж, олон төрлийн бүх хэлбэрийн тодорхой үйл ажиллагаанд татан оролцуулж, бүтээлч үйлээр нь дамжуулан чадавхижуулах шаардлагатай.
4. Сургалтын хөтөлбөрийг үнэлэх, сайжруулах, суралцахуйн удирдамж ба сурах бичиг боловсруулахдаа энэхүү гарын авлагад боловсруулсан багаж хэрэгсэл арга зүйг судлан хэрэглэх, мөн боловсролын түвшний ялгаа, судлагдахууны агуулгын чиглэлийн онцлогоос хамаарсан өөр багаж хэрэгсэл боловсруулж хэрэглэх боломжтой.
5. ТХ-д боловсролыг, боловсролд ТХ-ийг тус тус интеграцилах үйл явцыг гүнзгийрүүлэхдээ 2015 онд хийгдсэн **"Монгол Улсын тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлого, эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа"**⁷³ болон **"Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтны мэргэжил**

дээшлүүлэх үндсэн сургалтын хөтөлбөрт ТХБ-ын тусгагдсан байдлын үнэлгээ³ гэсэн судалгааны тайланд дурдагдсан ололт амжилт, алдаа дутагдал, тулгарч буй асуудал, тусгайлан ба ерөнхийлсөн үр дүн, дүгнэлт, санал зөвлөмжийг судлахад илүүдэхгүй.

6. Сургалтын цөм хөтөлбөрт ТХБ-ын интеграцчилалдсан байдлыг тодорхойлоход суурь болгон авсан ЮНЕСКО-ийн "Тогтвортой хөгжлийн зорилтууд: Суралцахуйн зорилтууд" (2017) гэсэн удирдамжид ТХЗ-ын суралцахуйн зорилтууд, сэдвүүд, хандлага, арга техникуудийг БНБ-ын түвшинд, сэдвийг глобаль түвшинд томъёолсон учраас боловсролын шатлал, ангиар ялган цөм хөтөлбөрүүдэд буулган хэрэглэхэд зарим талаараа бэрхшээлтэй байсан учраас тэдгээрийг боловсролын түвшинд харгалзуулан тусгайлах, мөн Монголын контекстүүдээ ТХЗ-д хамаарах сэдэвт харгалзуулахад тухайн асуудлаар ахисан түвшний мэргэшсэн (ТХ, ТХБ-оор) хүмүүс ажиллах шаардлагатай байна.

esd.itpod.mn

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ДЭЛХИЙ НИЙТИЙН БОЛОН МОНГОЛ УЛСЫН ТХ БА ТХБ-ЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИУУДЫН ИНТЕГРАЦ

Гарын авлагын энэ бүлэгт Дэлхий нийтийн тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролын хам утга, тэдгээрийн хөгжлийн стратегиудын замнал, агуулгын өрнөл ба интеграцын гүнзгийрэл улмаар Монгол Улс дахь эдгээр үйл явцыг тоймлон танилцуулна.

2.1. “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ” БА “ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ”-ЫН ХАМ УТГА

“Тогтвортой хөгжил” ба “Тогтвортой хөгжлийн боловсрол” гэсэн нэр томъёоны агуулгыг бүх нийтээрээ нэг мөр ойлгохгүйгээр боловсролыг ТХ-д интеграцчилах, ТХ-ыг боловсролд интеграцчилах гол стратегиуд хэрэгжих боломжгүй юм. Иймээс эхлээд энэ дэд бүлэгт гарын авлагын агуулга, зорилгалтын “сүнс” нь болох дээрх ойлголтуудын үзэл санааны үүсэл хөгжил, эдгээр ухагдахууны товч агуулга, тодорхойлолт, тэдгээрийн хам утгад хамаарах гол сэдэв, стратегийг тус тус холбогдох үндсэн баримт бичгүүдийн шинжилгээнд тулгуурлан танилцуулна.

Тогтвортой хөгжлийн үзэл санааны үүсэл хөгжил, товч агуулга

“Тогтвортой хөгжил (ТХ)” буюу “Sustainable Development (SD)” хэмээх нэр томъёоны хүрээнд дэх хөгжлийн үзэл санаа нь бүр XVIII зуунаас эхтэй. Тогтвортой хөгжил нь хүн төрөлхтний аж амьдралын өргөн цар хүрээг хамарсан, маш нарийн нийлмэл ойлголт бөгөөд түүний агуулга нь урт хугацааны туршид өргөжин гүнзгийрч цогц үзэл баримтлал болтлоо хөгжиж, бодит үйл хэрэг болон хэрэгжиж байгаа нь түүнийг хэвшмэл нэг утгаар тодорхойлох боломжгүй болгодог. ТХ-ийн тухай ойлголт, үзэл санааны үүсэл, хөгжлийн замналыг ерөнхийлөн тоймлохын тулд түүний талаар дэвшүүлж байсан анхны үзэл санаа, таамаглал, онол хийгээд дараагийн үе шатуудад НҮБ-аас Дэлхий нийтэд хандан гаргасан үүсэл санаачилга, тунхаглалын үзэл баримтлал, түлхүүр ойлголтуудыг харьцуулан авч үзэх шаардлагатай. (Хүснэгт 2.1.1)

Хүснэгт 2.1.1. ТХ-ийн үзэл санааны хөгжлийн замнал

Хөндөгдсөн асуудал	Гол ойлголтууд
1798, Томас Мальтус, “Хүн амын зарчим дахь эсээ” (An Essay on the Principle of Population, 1798) ⁵	Английн эдийн засагч Т.Мальтустын хүн амын өсөлтийн талаар дэвшүүлсэн онол нь ихэд алдаршжээ. 1818 онд эзэн хааны нийгэмлэгийн гишүүнээр сонгогдож байсан тэрээр “ямар нэг хяналтгүй бол хүн ам геометрийн прогрессоор өсөх тул хүн амын өсөлтөд хяналт тавих шаардлагатай” хэмээн үзсэн нь тухайн үедээ ихээхэн шүүмжлэлтд өртөж байв.
1962, Рэчел Карсон, “Чимээгүй хавар” роман (Silent Spring, 1962) ⁶	

3 БОНХАХЯ, ШХА, 2015. Монгол Улсын тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлого, эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа, УБ, 2015, хууд.250

4 БМДИ, ШХА, 2016. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хөтөлбөрт ТХБ-ын тусгагдсан байдлын үнэлгээний тайлан

5 Thomas Robert Malthus, 1798, An Essay on the principle of population. <https://ia902701.us.archive.org/14/items/essayonprincipleofpopulation00malt.pdf>болон хэтийн төлөвийн суурь судалгаа, УБ, 2015, хууд.250

6 Rachel Carson, 1962, Silent Spring. http://library.unt.edu/moreBooks_and_Reports/Silent_Spring_Rachel_Carson-1962.pdf